

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар оруулах/	Гүйцэт- гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Зорилт 1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг хугацаанд нь гаргаж холбогдох нэгж,	-	-Хугацаанд нь хүргүүлсэн Бодлогын баримт бичиг болон холбогдох хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн тоогоор;	Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2024 онд 5 биелэлт гаргаж, Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна.	1.Засгийн газрын газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийгмийн даатгалын холбогдолтой 5 зорилт, арга хэмжээ, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилт, арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг гаргаж, хугацаанд нь Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ. 2.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлтийг гаргах хугацаа болоогүй байна.	Хугацаа болоогүй

	албан тушаалтанд хүргүүлэх;						
1.2.	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахад холбогдох тооцоо судалгаа хийх;	-	- Боловсруулсан хуулийн төсөл; -Хийгдсэн тооцоолол, судалгааны тоогоор;	Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсэгт тус газраас 1 албан хаагч ажилласан.	Хууль батлуулахад шаардлагатай тооцооллыг хугацаанд нь гаргаж ГБХНХЯ-нд хүргүүлсэн байна.	1.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллуудыг хийв. Үүнд: - Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах: Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1 хувиар бууруулахад 261.0 тэрбум төгрөгөөр, 2 хувиар бууруулахад 523.0 тэрбум төгрөгөөр тус тус тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого буурах тооцооллыг гаргав. - Ажил олгогчийн ажилтанд олгосон цалин хөлсөнд дээд хэмжээг баримтлах: Ажил олгогчийн ажилтанд олгосон цалин хөлснөөс тооцох шимтгэлийн дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоовол нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 174.9 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав. - Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс тооцох шимтгэлийг уян хатан тогтоох: Ажил гүйцэтгэх гэрээ, Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагчийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар тогтоовол уг хуулийн өөрчлөлтөд 28.9 мянган даатгуулагч хамрагдаж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 25.3 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав. - ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2-1.0 хувиар бууруулах: Уг арга хэмжээний хүрээнд ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувийг 0.1-0.9 хувиар бууруулахад шимтгэлийн орлого 89.3 тэрбум төгрөгөөр буурах, 0.1 хувийг ажилгүйдлийн даатгалын санд шилжүүлэхээр тооцоход ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 25.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэх, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого нийт 115.1 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг	100

					гаргав. 2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллуудыг хийв. Үүнд: - Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох насыг нэмэгдүүлэх: Эмэгтэй даатгуулагч (55-60), 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн эх (50-55), газрын дор, хортой, халуун (эрэгтэй 50-55, эмэгтэй 45-50), хүнд (эрэгтэй 55-60, эмэгтэй 50-55) нөхцөлд ажиллагч, малчны (эрэгтэй 55-60, эмэгтэй 50-55) тэтгэвэр тогтоолгох насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 28.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав. - Тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох жилийг нэмэгдүүлэх: Тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох дараалсан 5 жилийг 10 жил болгон нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 32.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав. - Хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн эрх үүсэх хугацааг нэмэгдүүлэх: Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар” гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “нийтдээ 60 сар ба түүнээс дээш сар” гэж, Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар” гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг “нийтдээ 60-аас доошгүй сар, үүнээс тасралтгүй 36 сар” гэж тус тус нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 18.8 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав. 3.Тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн	
--	--	--	--	--	--	--

						төлөвийн тооцооллыг хийв. 4.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/48 дугаар тушаалын дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын мэргэжилтнийг ажиллуулав. 5.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиудын төслийг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.	
1.3.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг боловсруулах, батлуулах, нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах;	-	Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад өгсөн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг тухай бүр хүргүүлсэн байна.	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2024 онд 15 чиглэл, 14 зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	Дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна.	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2025 оны эхний хагас жилд 4 зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Үүнд: 1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх зөвлөмжийг аймаг, дүүргийн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 2.Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улстай “Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, ОХУ-ын иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь чирэгдэлгүй, шуурхай олгож ажиллах зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 3.Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх явцад аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын	100

						газруудаас ирүүлсэн зарим асуулгад холбогдох хууль, журам, дүрэм, зааврыг үндэслэн зохих зөвлөмж, чиглэлийг аймаг, дүүргийн аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 4.Батлан хамгаалахын сайд, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Заавар батлах тухай” А/95, А/81 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар”-ыг батлуулж, уг тушаалыг хэрэгжүүлэх зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.	
1.4.	Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод хүү тооцон эцсийн үлдэгдлийн талаарх мэдээллийг даатгуулагчдад хүргэх;	-	Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны үлдэгдлийн хэмжээ	Тэтгэврийн даатгалын нэрийн дансанд 2023 оны жилийн эцсийн байдлаар 1.6 сая даатгуулагчийн 33.2 их наяд төгрөгийн шимтгэл болон шимтгэлд тооцсон хүүг бүртгэсэн.	Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчдад мэдээлсэн байна.	Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу 11.34 хувь байхаар тогтоож, Үндэсний статистикийн хороо, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны саналыг тус тус авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/965 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хүүг баталсны дараа хүү тооцох ажлыг зохион байгуулна.	70
1.5.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг НДҮЗ-өөр	-	-Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээний тоо, - Санхүүжүүлсэн	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г батлуулав. Төлөвлөгөөнд 2025 оны эхний хагас жилд 28 арга хэмжээ зохион байгуулахаар тусгагдсанаас	90

	батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах;		хөрөнгийн хэмжээ	“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх төсвийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулж, хэрэгжүүлэх чиглэлийн хамт аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв.	хангагдсан байна.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 10 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 631.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 18 арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулахаар техникийн тодорхойлолтыг боловсруулж тендерийг зарлах бэлтгэл ажлыг хангаж байна.	
1.6.	Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хөдөлмөрийн	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зохион байгуулсан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2 арга хэмжээг зохион	Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажилласан байна.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Төлөвлөгөө батлах тухай” 06 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-ний 1.2-т тусгагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн	90

	аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;		сургалт, сурталчилгааны тоо	байгуулж, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 45.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон.		Үндэсний III чуулган” зохион байгуулах ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоог бэхжүүлбэ” уриан дор Төрийн ордны Их Монгол танхимд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулав. Чуулганд яамдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, 9 дүүрэг, 21 аймгийн ХАБЭА-н зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ажил олгогч, салбарын хяналтын байцаагч нар, аж ахуйн нэгж байгууллагуудын ХАБЭА-н зөвлөлийн гишүүд, ХАБЭА-н чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг их, дээд сургууль, сургалтын байгууллагууд, салбарын судлаачид, нийгмийн түншүүд зэрэг нийт 850 гаруй төлөөлөгч оролцлоо. Уг арга хэмжээний үеэр улсын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн 9 ажил олгогчийг шалгаруулан шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчилсан. Зохион байгуулсан арга хэмжээ болон холбогдох мэдээллүүдийг хэвлэл мэдээллийн цахим сайт, олон нийтийн телевизээр орон даяар түгээж ажиллав.	
1.7.	Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;	-	Хэрэгжилтийг хангуулсан хэлэлцээрийн тоо	Монгол Улс болон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд	Хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1.БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд ОХУ-д ажилласан хугацаагаа баталгаажуулах хүсэлт гаргасан 44 иргэний хүсэлтийг ОХУ-ын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлж, хоёр улсад ажилласан хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан 34 иргэний ажилласан жилийн тодорхойлолтыг баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлж, 40 иргэнд хэлэлцээртэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөв 2.БНСУ, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын Үндэсний	100

				Найрамдах Турк Улсын Засгийн газрын хооронд байгуулсан "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг ханган ажилласан.		тэтгэврийн албанд шимтгэл төлсөн 25 иргэний 128.9 сая вонны шимтгэлийн буцаан олголтын нэхэмжлэх, баримт бичгийг хүлээн авч Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлэв. 3.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Чех Улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 49 иргэний Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан тухай лавлагаа, 19 иргэний Бүгд Найрамдах Чех Улсад даатгалд хамрагдсан хугацааны гэрчилгээний хүсэлтийг БНЧУ-ын талд хүргүүлэв. 4.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Унгар Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд тус улсаас тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 9 иргэний, Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг баталгаажуулах 16 иргэний, 1 иргэний сануулах маягт, 11 иргэний дансны мэдээллийн маягт, Унгар улсаас өндөр насны тэтгэвэр авагч 25 иргэний оршин суугаа газрын хаягийн баталгаажуулалтыг Унгар Улсын талд хүргүүлэв. 5.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 3 иргэний мэдээллийг Польш Улсын талд хүргүүлэв.	
1.8.	Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээр шинээр байгуулах, хэлэлцээрийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах;	-	Хэлэлцээр шинээр байгуулахтай холбоотой ажилласан ажлын хэсгийн тоо	Монгол Улс Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс болон Австралийн Холбооны Улсын Засгийн газар	Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээр шинээр байгуулах ажлын хэсэгт ажилласан байна.	1.Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 13-ны өдрүүдэд зохион байгуулсан шинжээчдийн түвшний 3 дахь шатны уулзалтад оролцов. Уулзалтаар Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, харилцагч байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох маягтыг хэлэлцэх уулзалтыг 2025 оны 9 дүгээр сард Австри Улсын Вена хотод хийхээр харилцан тохиролцов. 2.Австралийн Холбооны Улстай нийгмийн	100

				хоорондын Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой шинжээчдийн багийн уулзалтыг зохион байгуулан ажиллах ажлын хэсгийн багт орж ажилласан.		хамгааллын хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлэх 2 дахь удаагийн уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Уулзалтад Австралийн Нийгмийн үйлчилгээний яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яам, Монгол Улс дахь Австралийн элчин сайдын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөлөл оролцож, дараагийн шатны хэлэлцээг 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулах, хэлэлцээрийн төслийг боловсруулах талаар санал солилцов. 3.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын газрын Орлогч дарга Хасенова Баян Зарлыковнатай 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад оролцов. Уулзалтаар талууд Хэлэлцээрийг соёрхон батлуулах явцын талаар харилцан мэдээлэл солилцов. 4.Бүгд Найрамдах Киргиз Улсын Нийгмийн сангийн газрын төлөөлөлтэй 2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдөр цахимаар уулзалт зохион байгуулан хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, тэтгэврийн бодлогын талаар харилцан туршлага солилцов. 5.Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх шинжээчдийн 5 дах удаагийн уулзалтад 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр оролцов. Уулзалтаар 2023 оны 12 дугаар сарын.08-ны өдөр зохион байгуулагдсан 4 дэх шатны хэлэлцээрийн мөрөөр авсан арга хэмжээг хэлэлцэн цаашдын хэлэлцээний талаар санал солилцов.	
1.9.	Гадаад орны нийгмийн	-	Зохион байгуулсан үйл	2024 онд хамтран	Олон улсын байгууллагатай	1.Гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны эхний хагас жилд хамтран ажиллах тухай	100

	даатгалын байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;		ажиллагааны тоо	ажиллах тухай нийт 5 албан бичгийг хүргүүлж, 5 олон улсын байгууллагатай 6 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллан 20,000 ам долларын санхүүжилт бүхий сургалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан.	хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байна.	найрсаг харилцааны нийт 7 албан захидлыг монгол, англи хэл дээр боловсруулж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ослын нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Ажилчдын Нөхөн олголт, халамжийн үйлчилгээний газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Будапешт хотын Тэтгэврийн даатгалын хэлтэс, Бүгд Найрамдах Чех Улсын Нийгмийн хамгааллын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн алба, Бүгд Найрамдах Польш Улсын Нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагад цахимаар хүргүүлэв. 2.Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хонконгийн Албан журмын хуримтлалын сангийн газар хооронд хамтран ажиллах Санамж бичгийн төслийг боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/785 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. 3.Бүгд Найрамдах Хятад Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран ажиллах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/722, 01/740, 01/766 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв. 4.Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах шинжээчдийн түвшний 3 дахь шатны уулзалтын хүрээнд Бүгд найрамдах Австри Улсын Европ болон олон улсын харилцааны яамны төлөөлөлтэй 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр уулзалт зохион байгуулж, талууд нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар танилцуулж, харилцан туршлага солилцож, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр болов.	
--	---	--	-----------------	--	---------------------------------------	---	--

						5.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр 23,400 ам долларын үнэ бүхий Нийгмийн даатгалын үйлчилгээний гарын авлага хэвлүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, видео контент хийх зэрэг чиглэлээр хамтран ажиллав. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран “Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах” сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын нийт 90 албан хаагч хамрагдав. 6.Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас 2025 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх Техникийн хамтын ажиллагааны төсөлд “Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах арга хэрэгсэл, авлагын менежмент” төслийг хэрэгжүүлэх саналыг монгол, англи хэл дээр боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1289 дүгээр албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.	
1.10.	Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, иргэд, даатгуулагч, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах;	-	Ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, иргэд, даатгуулагч, олон нийтэд танилцуулсан мэдээлэл, сурталчилгаа, сургалтын тоо	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийн талаар ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, сурталчлах, сургалтыг 2024 онд нийслэлийн 9	Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, иргэд, даатгуулагч, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулсан	Нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.МҮОНТ, SBN телевизүүдэд “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр”, “Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол” зэрэг сэдвүүдээр тус тус мэдээлэл өгөв. 2.Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Албан журмын даатгуулагчдын холбоо зэрэг байгууллагуудын 140 гаруй ажилтнуудад “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл” сэдвээр, Тагнуулын ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газрын 60 гаруй албан хаагчдад “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр, нийт 200 гаруй даатгуулагчдад мэдээлэл өгөв. 3.Дорноговь, Дархан-Уул аймгийн Нийгмийн	100

				дүүрэг, 21 аймгийн хэмжээнд зохион байгуулж, 14 төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын 650 гаруй иргэд, даатгуулагчдад хууль тогтоомжийг сурталчилсан.	байна.	даатгалын газраас зохион байгуулсан “Ажил олгогчийн зөвлөгөөн”-д оролцож 2 аймгийн 800 гаруй ажил олгогчийн дарга, захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэлэлтийн хэрэгжилт” сэдвээр мэдээлэл өгч, 100 гаруй ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой асуултад хариулж, мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав.	
1.11.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулах, гэрээ, санамж бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг шинэчлэх санал боловсруулах;	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 34, НД04/24 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулав.	Гэрээ, санамж бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, шинэчлэн байгуулах санал боловсруулж, батлуулсан байна.	1.Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 онд байгуулсан НД04/24 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г дүгнэж, 2025 оны НД09/25, ЭМДЕГ-25/27 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-г шинэчлэн байгуулав. 2.Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн хооронд 2024 оны НДСБ-02 дугаартай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгуулав. 3.Мөн тус байгууллагатай Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, ач холбогдлын талаар ажил олгогч, иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд, олон улсын туршлага сэдэвт сургалт зохион байгуулахаар 2025 оны НД-49/25 тоот “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулав. 4.Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгуулагчдын эрх ашийг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 5 жилийн хугацаатай байгуулав. 5.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил	100

						олгогч, эздийн болон бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалахаар Монгол ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимуудтай хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулахаар санамж бичгийн төслийг тус байгууллагуудад хүргүүлэв.	
1.12.	Цэргийн алба хаагчид тэтгэвэр тогтоох, олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр цэргийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, шинэчлэн байгуулах;	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Тагнуулын ерөнхий газартай НД-03/24, 08/24 дугаартай “Нийгмийн даатгалын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар хоорондын цэргийн тэтгэврийн чиглэлээр хамтран ажиллах гэрээ”, Зэвсэгт хүчний Жанжин штабын Тагнуулын газартай нууцын зэрэглэлтэй хамтран ажиллах гэрээг тус тус шинэчлэн байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллав.	Гэрээ, санамж бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, шинэчлэх санал боловсруулж, батлуулсан байна.	1. Цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тэдэнд үзүүлэх тэтгэврийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны цэргийн байгууллагуудтай байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд цэргийн 10 байгууллагад гэрээнд өөрчлөлт оруулах саналыг ирүүлэх тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/735 дугаар албан бичгийг хүргүүлэв. 2.Батлан хамгаалахын сайд, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Заавар батлах тухай” А/95, А/81 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар”-ыг хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.	100
1.13.	Нийгмийн даатгалын сангийн	НДС-ийн орлого	Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын	Аймаг, дүүргийн төсвийн	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны	100

	2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	5,893.3 тэрбум төгрөг /Улсын төсвийн татаас орсон дүн/, Зарлага 5,188.4 тэрбум төгрөг	ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг олгосон байна.	сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэн, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын төсвийг олгосон байна.	төсвийн хуваарь батлах тухай” А/01, “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/15, А/50, А/143 дугаар тушаалуудаар нийгмийн даатгалын сангийн аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарийг батлуулан, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.	
1.14.	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад	Үйл ажиллагааны урсгал зардал 75.1 тэрбум төгрөг	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг олгосон байна.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж,	Аймаг, дүүргийн төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг олгосон байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай” А/02, “Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/16, А/49, А/129 дүгээр тушаалуудаар нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын нарийвчилсан хуваарийг батлуулан, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.	100

	хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;			хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.			
1.15.	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны жилийн хязгаарын саналыг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх;	-	Хуулийн хугацаанд боловсруулж хүргүүлсэн төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн хязгаарын санал	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2025-2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны жилийн хязгаарын саналыг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны жилийн хязгаарын саналыг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Санал хүргүүлэх тухай” 01/636 дугаар албан бичгээр, нийгмийн даатгалын сангийн 2026 оны жилийн хязгаарын саналыг 2025 оны “Санал хүргүүлэх тухай” 04/1333 дугаар албан бичгээр тус тус Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Уг саналд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг хэвийн өсөлтөөр, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан 8.0 хувиар нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох дараалсан 5 жилийн дээд хязгаарыг 2,400.000 төгрөг болгох зэрэг өөрчлөлтүүдийг тусган нийгмийн даатгалын сангийн орлогыг 8,794.4 тэрбум төгрөгөөр, үүнээс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийг 2,774.8 тэрбум төгрөгөөр, сангийн нийт зарлагыг 6,963.5 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.	100
1.16.	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг жендерийн	-	-2025 оны 07 сарын 20-ны өдрийн дотор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн төсөл, төсөөлөл	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2025 оны төсвийн төсөл, 2026-	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг 2025 оны 07 дугаар	II-III улирал	Хугацаа болоогүй

	мэдрэмжтэй төлөвлөлт ба төсөвлөлтийн аргаар боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр тус тус хэлэлцүүлж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх;			2027 оны төсөөллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэн, Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	сарын 20-ний дотор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.		
1.17.	Монгол Улсын төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн аймаг, нийслэлийн	-	-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн Аймаг, дүүргийн, сар, улирлын хуваарийн саналын тоо	2025 оны төсвийн аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	2026 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан 2025 оны 12 дугаар сарын 15-ны дотор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	IV улирал	Хугацаа болоогүй.

	нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх;						
1.18.	Нийгмийн даатгалын байгууллагуудыг нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсөв, төлөвлөгөө боловсруулах нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;	-	Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмж, чиглэлийн тоо, Зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, үр дүн	Холбогдох асуудлаар 27 удаагийн зөвлөмж, чиглэлийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллав.	Нийгмийн даатгалын байгууллагуудын төсөв, төлөвлөгөө хуулийн хугацаанд боловсруулагдсан байна.	Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийг баталсан аргачлал, зөвлөмжийн дагуу сум, дүүрэг, тасгийн холбогдох байцаагч, ажилтнуудыг ажлын хэсэгт ажиллуулан боловсруулж, цахим системээр 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх зөвлөмж, чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын даргын 2025 оны “Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай” 04/1364 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв.	Хугацаа болоогүй
1.19.	Нийгмийн даатгалын салбарын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэх, жендерийн нарийвчилсан үзүүлэлтээр баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх;	-	Статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэн, нарийвчилсан баяжуулсан мэдээллийн сангийн тоо	2023 оны жилийн эцсийн статистик үзүүлэлтийг шинэчилсэн.	2024 оны жилийн эцсийн статистик үзүүлэлтээр шинэчилсэн байна.	1.Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тоо, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг статистик мэдээллийг аймаг, дүүргээр 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн гаргав. 2.Нийгмийн даатгалын салбарын 2024 оны статистик мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” А/175 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу гаргаж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/1170 дүгээр албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр,	100

						нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлэв.	
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
Зорилт 2: “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох;	-	Төсвийн зардлыг 5,882,758.8 сая төгрөгөөс хэтрүүлэхгүй байна.	Нийгмийн даатгалын сангаас 5,087,002.64 сая төгрөгийн зардал олгосон.	Нийгмийн даатгалын сангаас 5,882,758.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно.	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны жилийн Төсвийн тухай хуулиар эхний хагас жилд 2,962.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгохоос 2,907.9 тэрбум төгрөг олгож 98.16 хувийн биелэлттэй, зарлагын гүйцэтгэлийг хангуулав. Үүнд: - Тэтгэврийн даатгалын сангаас 2,691.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 2,650.4 тэрбум төгрөг; - Тэтгэмжийн даатгалын сангаас 151.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 144.4 тэрбум төгрөг; - Ажилгүйдлийн даатгалын сангаас 84.6 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 86.7 тэрбум төгрөг; - ҮОМШӨ-ний даатгалын сангаас 34.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 26.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулав.	98.16
2.2.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах;	-	Тайлагнасан тоо	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг 2 удаа зохион байгуулсан.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлнэ.	1.Нийгмийн даатгалын 34 байгууллагын сангийн болон байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг хүлээн авч, нэгтгэн Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд тус тус тогтоосон хугацаанд хүргүүлж, 6 удаагийн мэдээг хугацаанд нь баталгаажуулав. 2. Нийгмийн даатгалын байгууллагуудад 2024 оны жилийн эцсийн, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах хуваарийг хүргүүлэн мэргэжил арга зүйн зааварчилгаа өгч, тайлангуудыг хуульд заасан	90

						хугацаанд нэгтгэж, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв. 3.Үндэсний аудитын газраас "Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хязгаарлалттай дүгнэлт авсан ба Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна" гэж дүгнэсэн. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн танилцуулгыг бэлтгэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хуулийн хугацаанд хүргүүлэв. 4.Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2024 он, 2025 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт, биелэлт, сар бүрийн сангийн болон урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn сайтад хуулийн хугацаанд байршуулав. 5.Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын нэгтгэл тайлангийн нэгтгэлд тус бүр хуулийн хугацаанд хүргүүлэв.	
2.3.	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулах, гэрээний биелэлтийг хангах;	-	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хууль, дүрэм, журмын дагуу удирдсан байна.	Засгийн газрын дотоод үнэт цаас 300,000.0 сая төгрөгөөр худалдан авсан.	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулж, гэрээний биелэлтийг хангана.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн тооцооллыг нийгмийн даатгалын төрөл тус бүрийн бие даасан сангуудаар хийж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлснээр Нийгмийн	100

					даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, 08 дугаар тогтоолоор мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн тус тус баталсан. Банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудаас 2-3 удаа санал авч Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан хүүгийн хэмжээнээс багагүй санал ирүүлсэн Хаан, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкуудад сар бүр хүү олгох нөхцөлтэй 1 жилийн хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах санал, гэрээний төслийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо болон Олон нийтийн хяналтын зөвлөлд хүргүүлэн санал, дүгнэлт авч ажиллав. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэй, сар бүрийн эцэст хүү тооцох нөхцөлтэй нэг жилийн хугацаатай хадгалуулахаар мөнгөн хадгаламжийн гэрээг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хаан, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн бангтай байгуулан мөнгөн хөрөнгийг байршуулсан. Энэ тухай мэдээллийг https://shilendans.gov.mn/ сайтад хуулийн хугацаанд байршуулав. Банкуудтай байгуулсан гэрээний дагуу 5 дугаар сарын хүүгийн орлогоор 8.6 тэрбум төгрөгийг хүлээн авав. Хугацаатай мөнгөн хадгаламжид хөрөнгө оруулснаар жилийн хугацаанд нийтдээ 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах боломжийг бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2025 оны	
--	--	--	--	--	--	--

						“Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 (гурван зуун) тэрбум хүртэлх төгрөгөөр тус тус баталсан. Хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор 2025 онд Засгийн газрын дотоод үнэт цаасыг хөрөнгийн биржээр нээлттэй худалдаж байгаа тул нийгмийн даатгалын ерөнхий газар уг арилжаанд үнэт цаасны компаниар зуучлуулан оролцох шаардлагатай болсон. Нээлттэй арилжаанд оролцох бэлтгэл ажлын хүрээнд Засгийн газрын 2024 оны “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар төслийг бэлтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/1228 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.	
2.4.	Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, даатгуулагч тус бүрээр хуваарилах ажлыг зохион байгуулах, судалгаа, тооцоог хийж, холбогдох газарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангах;	-	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хууль, дүрэм, журмын дагуу удирдсан байна.	Тэтгэврийн нөөц санд 212.2 тэрбум төгрөгийг байршуулсан.	Мөнгөжүүлэхэд бэлэн орлогын мэдээллийг сар бүр Мэдээллийн технологийн төвөөс авч тэтгэврийн нөөц санд байршуулж, мэдээлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар заасны дагуу 2025 онд 25.0 тэрбум төгрөгийг нэмж байршуулснаар нөөц сангийн үлдэгдэл нийтдээ 242.8 тэрбум төгрөг байна. Мөнгөжүүлсэн орлогын мэдээллийг иргэд, даатгуулагчдад гар утасны нийгмийн даатгал аппликейшн, https://portal.ndaatgal.mn/ систем, И-монголиа системээр мэдээлж ажиллав.	85
2.5.	Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банк ХХК-аас нэхэмжилсэн өр төлбөрийг	300.0 сая төгрөг	Өр төлбөрийн бууралт	Капитал банкны өр төлбөрийн үлдэгдэл 65.7 тэрбум төгрөг, Чингис хаан банкны өр	Капитал банк болон Чингис хаан банкны өр төлбөрийн үлдэгдлийг бууруулсан байна.	1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны урсгал үйл ажиллагааны батлагдсан төсвийн хүрээнд Чингис хаан банк ХХК, Капитал банк ХХК-иас авах нийгмийн даатгалын сангийн авлагыг бүрэн барагдуулахад төлбөр авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалан эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах	80

	барагдуулах зорилгоор мэргэшсэн өмгөөлөгч, мэргэжлийн хуулийн байгууллагатай хамтран ажиллах;			төлбөрийн үлдэгдэл 95.2 тэрбум төгрөг байна.		шатны шүүх, улсын дээд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамгаалах, төрийн бусад байгууллагад Нийгмийн даатгалын ерөнхий газрыг төлөөлөх өмгөөллийн эрхтэй хуулийн этгээдээс хууль зүйн туслалцаа авахаар 300.0 сая төгрөгийн төсөвтэй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх этгээдийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын НДЕГ/20250103001 дугаартай тендерийн урилгыг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан боловч тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг хангасан тендерийг оролцогчид ирүүлээгүй тул тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулж, тендерийн урилгыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан. 2. Капитал банк ХХК, Чингис хаан банк ХХК-иас нэхэмжилсэн оны эхний авлагын дүн 160.9 тэрбум төгрөгөөс 3.8 хувь буюу 6.13 тэрбум төгрөгийн төлбөр барагдсан байна. Үүнд: - Капитал банк ХХК-иас нэхэмжилсэн 104.2 тэрбум төгрөгийн авлагаас 2025 оны 06 сарын 04-ний өдрийн байдлаар нийт 38.8 тэрбум (2025 онд 0.3 тэрбум) төгрөгийн төлбөр барагдаж, 65.40 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй; - 2.Чингис хаан банк ХХК-иас нэхэмжилсэн 103.57 тэрбум төгрөгийн авлагаас 2025 оны 06 сарын 04-ний өдрийн байдлаар нийт 14.2 тэрбум (2025 онд 5.83 тэрбум төгрөг) төгрөгийн төлбөр барагдаж, 89.37 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.	
Зорилт 2.1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүгээр хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1.1	Сайн дурын даатгалын	-	Сайн дурын даатгалд	2024 онд 28.1 мянган хүнийг	Сайн дурын даатгуулагч	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын	85

	хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;		шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, -Өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	сайн дурын даатгалд шинээр, үүнээс 9.0 мянган малчин шинээр хамруулав.	(малчин)-ийн тоог өмнөх оны суурь түвшин 60,6 хувиас зорилтот түвшин 61.75 хувь, үүнээс малчин даатгуулагчийг 24 хувиар нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар “2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн орон тооны төлөвлөгөө”-г батлан уг төлөвлөгөөнд сайн дурын даатгалд нийт 199.7 мянган даатгуулагч, үүнээс 26.9 мянган даатгуулагчийг шинээр хамруулахаар тусгаж аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв. 2025 оны эхний 5 сарын байдлаар сайн дурын даатгалд 120.4 мянган хүн хамрагдаад байна. Үүнээс: - Энгийн сайн дурын даатгалд 73.2 мянган; - 0-3 настай хүүхдээ асарч буй эх 6.6 мянган; - Малчин 37.8 мянган; - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг /эх/ 2.8 мянган хүн тус тус хамрагдав. Сайн дурын даатгалын ач холбогдол, хамралтыг нэмэгдүүлэх талаар С1 телевиз, Монголын үндэсний олон нийтийн радио телевизэд ярилцлага, лайваар иргэд даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгч, сонирхсон асуултад хариулж байна.	
4.8	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	-НДЕГ-ын даргын баталсан “Шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөө” 1 -Тайланг хугацаанд нь хүргүүлж, үнэлгээний хувь нэмэгдсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлсэн. Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 74,5 хувиар үнэлсэн байна.	-Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. -Төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.	1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын Шударга байдлын үнэлгээ 2023 онд 69.5 хувь, 2024 онд 74.5 хувиар үнэлэгдэж 5 хувиар дээшлүүлсэн тул 2025 онд Шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр батлаагүй болно. Харин Нийгмийн даатгалын байгууллагын Шударга байдлын үнэлгээг сайжруулах үүднээс Нийгмийн даатгалын байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд Шударга байдлын үнэлгээг сайжруулах 1 арга хэмжээ тусган Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/105 дугаар тушаалаар батлав. 2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны Шударга байдлын үнэлгээний судалгаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 30 албан хаагчийг түүврийн аргаар сонгон хамруулав. “Шинжээч”-д Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 10 албан хаагч, хамран ажилладаг нэр бүхий 5 банкны албан хаагч, Эрүүл мэндийн магадлалын төв болон салбар зөвлөлийн шинжээч 5 эмч нийт 20 хүнийг хамруулахаар нэрсийг эрх бүхий судалгааны байгууллагад хүргүүлсэн. 3. “Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийг нэгтгэн 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэхээр зохион байгуулан ажиллаж байна.	100
4.9	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;	-	-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; -Нийгмийн	2024 оны 05 дугаар сарын 31-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газрын	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс Нийгмийн даатгалын ерөнхий	Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь тайлант хугацаанд дараах ажлыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд: 1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө”-г 2025 оны 03 дугаар сард хэлэлцэн баталж уг төлөвлөгөөнд	100

			даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх; -Баталсан төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 удаа хийсэн байна.	Ёс зүйн дэд хороог байгуулсан 2024 оны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлсэн, салбар байгууллагын Ёс зүйн дэд хорооны судалгааг гарган нэгтгэсэн.	газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Нийгмийн даатгалын салбарын “Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлах, сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зэрэг 10 арга хэмжээг зохион байгуулахаар тусгав. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө”-г Төрийн албаны зөвлөлийн “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт” дэд системд байршуулав. 2. Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд 2 гомдол, 1 мэдээллийг иргэн, албан хаагч, ёс зүйн дэд хорооноос ирүүлсэн. Үүнээс: нэг гомдол, нэг мэдээллийг шалгаж дүгнэлт гаргаснаас нэг нь Ёс зүйн зөрчил гаргасан, нэг нь ёс зүйн зөрчилгүй гэж дүгнэгдсэн бөгөөд 1 гомдол нь хяналтын шатанд үргэлжилж байна. 3.Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны нэг гишүүн сургагч багшаар, Дэд хорооны дарга болон нэг гишүүн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцов. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны даргаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт үе шаттай сургалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр батлав. Уг хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхижуулах сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж танхим, цахим, дадлага хосолсон сургалтад нийт 130 гишүүн хамрагдав. 4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн зарчмаар “Төрийн албан хаагч бид” гэх постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, 30 нэгжийн цахим хуудаст байршуулан түгээв.
--	--	--	---	--	---	---

Зорилт 4.1: “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхижуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

4.1.1	“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийг хэрэгжилтийг хангах үүднээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад үндэсний монгол бичгийн сургалтыг зохион байгуулах;		-Сургалтад нийт ажилтнуудын 90-ээс дээш хувийг хамруулах, -дундаас дээш үнэлэгдсэн албан хаагчдын тоо	Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад 163 албан хаагчдыг цахимаар хамруулсан.	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, сургалт зохион байгуулах ажлыг удирдлагаар хангах, Сургалт зохион байгуулж, албан хаагчид мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын даргын 2025 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/07 дугаар тушаал, НД№10 дугаартай “Сургалтын гэрээ”-нд үндэслэн үндэсний бичгийн сургалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 93 албан хаагчийг хамруулан, 2025 оны 01 дүгээр сарын 13-наас 02 дугаар сарын 26-ны өдрийн хооронд танхимаар зохион байгуулав. “Тарвалин хийд”-ийн дэргэдэх шашны сургуулийн үндэсний монгол бичгийн Б.Базаррагчаа багшийн заасан нийт 20 удаагийн хичээл буюу 40 академик цагийн сургалтаар Монгол бичгийн үүсэл, үндсэн болон нэмэлт зурлага, тоо бичих, эгшиг үсэг, эгшиг зохицох ёсон, зөөлөн, хатуу дэвсгэр үсгийн дүрэм, үсэг холбох, төсгөх дүрэм, гадаад үг тэмдэглэх, дагавар, тийн ялгалын нөхцөл, монгол бичгийн фонт суулгах, ашиглах, дадлага ажлуудыг гараар бичих, компьютерээр бичих, гэрийн даалгавар, багаар ажиллуулан, тухай бүр шалган үнэлгээ өгч ажиллав.	100
4.1.2	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалт зохион байгуулах;		-2-оос доошгүй удаа зохион байгуулах, -Улсын байцаагчийн эрх олгогдсон албан хаагчдын тоо	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2024 оны шалгалтад нийт 299 албан хаагч хамрагдаж, 162 албан хаагч тэнцэж, 137 албан хаагч хангалтгүй үнэлэгдсэн.	Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад улсын байцаагчийн эрх олгогдсон байна.	1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн журам”, 2023 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын төслийг боловсруулж, Газрын дарга нарт хүргүүлж саналыг авч тусгах ажил хийгдэж байна. 2.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын мэдээллийн нэгдсэн сантай болох ажлын хүрээнд 2014-2024 оны улсын байцаагчийн шалгалтад хамрагдсан албан хаагчдын мэдээллийг цаасан суурьтай баримтаас өхсөл рүү хөрвүүлэн боловсруулах ажлыг эхлүүлээд байна. 3.Улсын байцаагчийн шалгалтын тов товлогдоогүй байна.	Хугацаа болоогүй
4.1.3	Нийгмийн		-Салбарын	Албан хаагчдыг	Сургалтын	1.Нийгмийн даатгалын салбарын 542 байцаагч,	100

	даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;		хэмжээнд сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, -Албан хаагчдыг 100% хамруулсан байна.	чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 1,039 удаагийн сургалтад 18,261 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулсан.	хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна.	ажилтнуудыг хамруулан сургалтын хэрэгцээг тодорхойлох асуумж судалгааг зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтын хэрэгцээний үр дүнд үндэслэн Нийгмийн даатгалын байгууллагын 2025 онд зохион байгуулах 3 бүлэг бүхий 31 сургалтын төлөвлөгөө батлуулж, Захиргаа удирдлагын газрын даргын 2025 оны 03/425 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн. 2.Нийгмийн даатгалын байгууллагын сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулан, нэгжийн болон Газрын даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгээд байна. Хөтөлбөрт сургалтын зорилго, хамрах хүрээ, үйл ажиллагаа, зарчим, сургалтын хэлтэс болон сургагч багшийг чадавхижуулах, нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын богино, дунд, ахисан түвшний сургалтын хөтөлбөр, иргэд, даатгуулагч, ажил олгогчдод зориулсан сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжүүлэх хугацаа, үр дүн, хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалтын нэгдсэн хөтөлбөр, сургалтын процессын зураглал, 2026 оны сургалтын төсвийн төсөл, сургалтын өмнө буюу дараах асуумж судалгааны загварыг тусгасан. 3.Салбарын хэмжээнд тайлант хугацаа (2025 оны 06 дугаар сарын 06-ний өдрийн байдлаар)-нд нийгмийн даатгалын албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 768 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтад давхардсан тоогоор 15,194 албан хаагчдыг танхим болон цахимаар хамруулснаас Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан 23 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт танхимаар 1771, цахимаар 1791, давхардсан тоогоор 3562 албан хаагчийг хамруулав. Мөн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд болон тус зөвлөлийн үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжилтнүүдэд зориулсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох”, “Эрүүл мэндийн магадлалтай холбоотой тушаал
--	---	--	---	--	---	--

						шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллахад анхаарах асуудал” сэдэвт 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд 1,250 гаруй албан хаагчид хамрагдсан байна. Сургалтын платформд 31 видео хичээл, 27 илтгэл (ppt)-ийг байршуулан, албан хаагчдыг боломжтой цагтаа өөрийн нэвтрэх эрхээр орон хичээлүүдийг бие даан судлах боломжийг бүрдүүлэв. 4.Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад цаг үеийн шинжтэй болон шинэ шинэлэг мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор 11 удаагийн мэдээллийн цагийг зохион байгуулсан бөгөөд танхимаар 567, цахимаар 1348, нийт 1915 албан хаагчид хамрагдав.	
4.1.4	Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;		-Даатгуулагчид чиглэсэн сургалтыг салбарын хэмжээнд өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, - 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, -Ажил иргэд, даатгуулагчдын 150-иас доошгүй хувийг хамруулсан байна.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 45 удаагийн сургалтад 6171 аж ахуйн нэгжийн 127544 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулав.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна.	1.Салбарын хэмжээнд тайлант хугацаа (2025 оны 06 дугаар сарын 06-ний өдрийн байдлаар)-нд иргэд, даатгуулагч ажил олгогчдод нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг сурталчлан таниулах, тэдний ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 1,778 удаагийн танхимын болон цахим сургалтыг 9,458 аж ахуйн нэгжийн 104,957 иргэд, даатгуулагчийг хамруулан зохион байгуулснаас Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 12 удаагийн сургалтад 2,765 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулан, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх зөвлөгөө, мэдээллийг түгээн ажиллав 2.Төрийн болон төрийн бусд байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, гуравдугаар шатлалын эмнэлэг, төрийн болон хувийн их, дээд сургууль, арилжааны даатгалын компани, арилжааны банк зэрэг нийт 13 байгууллагын 610 ажилтан, албан хаагчдыг хамруулан “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл”-ийн талаар сургалт зохион байгуулав.	100
4.1.5	“Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-ийн бэлтгэл	-	-Салбарын хэмжээнд архив, бичиг	-Нийгмийн даатгалын ерөнхий газрын	-Нийгмийн даатгалын ерөнхий газрын архивын	1.2025 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтлөхтэй холбоотойгоор Архивын ерөнхий газартай хамтран	70

	ажлыг хангах;		хэргийн ажилтнуудад 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо -Цахим баримтыг хадгалах, хамгаалах, ашиглах талаар зохион байгуулсан ажлын тоо	1998-2009 оны түр хадгалах архивын баримтаас хугацаа дууссан баримтыг устгалд оруулсан -Баримтын бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангах, галын аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс галын хор шинэчлэн стандартын дагуу галын хорийг шинээр байрлуулсан. Хортон шавьж, мэрэгч амьтнаас урьдчилан сэргийлж архивын өрөөнд хулганы хор тавьсан.	өрөөнд засвар хийнэ. -Хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай саналын Архивын ерөнхий газарт хүргүүлнэ. -Салбарын хэмжээнд архив, бичиг хэргийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна. -Цахим баримтыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг зохион байгуулсан байна.	байгууллагын албан хаагчдад Үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах арга зүй сургалтыг зохион байгуулав. 2.Архивын ерөнхий газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/146 дугаар албан бичгийг хүргүүлснээр албан хэрэг хөтлөлтөд ашигладаг хэвлэмэл хуудасны эхийг “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдлийн байрлалд тавих үндсэн шаардлага” MNS 6395: 2022 стандартын монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудсанд байх бүрдэл болон тавигдах шаардлагад нийцүүлэн бэлтгэж Архивын ерөнхий газрын Хяналт шалгалтын газраар хянуулан хэвлүүлж албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр хөтөлж эхлэв. 3.“Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” болохтой холбогдуулан нийт албан хаагчдад “Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны зөвлөмж” гарган Албан хэрэг хөтлөлтийн “Able” программын Олон нийтийн хэсэгт байршуулж, дотоод бичгээр албан хаагчдад мэдээлэл өгөв. 4. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт архив болон бичиг хэргийн ажилтнууд хамтран бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна. 5.Архивын ерөнхий газраас “Архивын баримтын хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ыг шинэчилж байгаатай холбогдуулан Нийгмийн даатгалын холбогдолтой баримт бичгийн саналыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудын архивын ажилтнуудаас авч нэгтгэн БНШК-оор хэлэлцүүлэн саналыг Архивын ерөнхий газарт Захиргаа удирдлагын газрын даргын 2025 оны 03/548 дугаартай албан бичгээр хүргүүлэв.	
4.1.6	Албан бичгийг “Цахимаар албан бичиг солилцооны дундын систем”-тэй холбогдсон бусад байгууллагуудтай 100 хувь цахимаар	-	Нийгмийн даатгалын байгууллага “Цахимаар албан бичиг солилцооны дундын	Нийгмийн даатгалын байгууллага нь 2024 оны жилийн эцсийн байдлаар цахимаар	Нийгмийн даатгалын байгууллага нь цахимаар албан бичиг солилцох ажлыг тогтмолжуулж,	Нийгмийн даатгалын байгууллага “Цахимаар албан бичиг солилцооны дундын систем”-тэй холбогдсон бөгөөд цахимаар албан бичиг хүлээн авах, илгээх ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна. 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар цахимаар албан бичиг солилцох ажил 57 хувьтай байна.	100

	солилцох;		систем”-тэй холбогдсон байгуулагуудт ай цахимаар албан бичиг илгээх, хүлээн авах ажлыг зохион байгуулж, тогтмолжуулсан байна.	албан бичиг солилцох ажил 20 хувьтай байна.	биелэлтийн хувийг өсгөсөн байна.	Тайлант хугацаанд нийт 2,561 албан бичиг ирснээс 60.6 хувь буюу 1,553 цахимаар ирсэн бичиг бичиг байна. Харин бусад газарт 1,373 албан бичгийг явуулснаас 54.2 хувь буюу 744 цахимаар явуулсан бичиг байна. <i>Тайлбар:</i> Төрийн байгууллагуудаас ирсэн болон явуулсан бичгийг цахимаар солилцож хэвшсэн бөгөөд Хувийн байгууллагууд цахим системийг ашигладаггүй ирсэн, явуулсан албан бичиг: цаасаар албан бичгийг шуудангаар ирүүлэх, өөрсдөө биеэрээ авчирч өгөх тохиолдлууд байдаг ба ирүүлсэн албан бичгийн хариу нь эх хувиар цаасаар хүргэгддэг болно.	
Зорилт 4.2: “Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.2.1	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн хэрэглээг сайжруулах зорилгоор иргэд, даатгуулагч, ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэх, сайжруулах санал боловсруулах;	-	-Зохион байгуулсан судалгааны тоо, -Оролцогчийн тоо	-	Сэтгэл ханамжийн судалгааг нийт 4 удаа авч дүгнэн, санал боловсруулсан байна.	Иргэд, даатгуулагч, ажил олгогчоос авах нийгмийн даатгалын мэдээллийн системийн хэрэглээний талаарх сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг боловсруулж, иргэний болон ажил олгогчийн портал систем (portal.ndaatgal.mn)-д байршуулан, дүнг сар бүр нэгтгэн боловсруулав. Тайлант хугацаанд судалгаанд 849 ажил олгогч, 2,519 иргэд, даатгуулагч оролцсон байна. Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь системийн хурд, найдвартай ажиллагааг сайжруулах, техникийн алдааг багасгах, процессын шат дамжлагыг цөөлөх, системийн шинэчлэлийн талаарх хэрэглэгчдэд зориулсан дэлгэрэнгүй, ойлгомжтой заавар, мэдээллийг цахимаар болон утсаар тогтмол хүргэх, байцаагч, мэргэжилтнүүдийн харилцаа, мэдлэг, ур чадварыг сайжруулах, тэтгэмжийн шийдвэрлэлт, олголтыг хугацаанд нь, ил тод, хяналттай байлгах зэрэг санал ирүүлсэн байна.	100
4.2.2	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй	-	-Зохион байгуулсан судалгаа, -Оролцогчийн	Нээлттэй өдөрлөгт 6742 иргэд, даатгуулагчдыг	Сэтгэл ханамжийн судалгааг нийт 2 удаа авч дүгнэн, санал	1.Нийслэлийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний стандартын хэрэгжилтэд 3 дугаар сард тандалт, судалгаа хийж ажиллав. Арга хэмжээний явцад тухайн дүүргээр	80

	холбоотой иргэдийн сэтгэл ханамжийг судалгаа авч дүгнэх, сайжруулах санал боловсруулах;		тоо	судалгаанд хамруулсан.	боловсруулсан байна.	үйлчлүүлж байсан 115 иргэнээс нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх 12 асуумж бүхий сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг нэгтгэсэн. Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд 46-65 насны иргэд илүү их үйлчлүүлж байсан ба залуу үеийн даатгуулагчид үйлчилгээ авах нь бага байгаа харагдаж байна. Үйлчлүүлж байгаа иргэдийн дийлэнх нь тэтгэврийн насны иргэд байна. Судалгааны дүнгээр оролцогчдын дийлэнх нь тэтгэвэр, сайн дурын даатгал, шимтгэл төлөлттэй холбоотой дүрэм журмуудыг илүү сонирхож, хууль тогтоомж, дүрэм, журмын мэдээллийг цахим орчинд олон нийтийн сүлжээгээр илүү хүртээмжтэй түгээх санал өгсөн. Байцаагчийн харилцаа хандлагад сэтгэл ханамж өндөр байгаа боловч иргэдэд өгч байгаа мэдээллээ ойлгомжтой, дэлгэрэнгүй тодорхой хүргэх, мэдээлэл дутуу авснаас иргэд дахин хандахад хүрч байгааг анхаарах зэрэг санал ирүүлсэн. 2.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн явцад зөвлөгөө, мэдээлэл авсан 49 иргэнээс 9 асуумж бүхий сэтгэл ханамжийн судалгаа авч дүнг нэгтгэлээ. Өдөрлөгийн явцад ихэнх оролцогчид тэтгэвэр болон сайн дурын даатгалын мэдээлэл сонирхож, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хангалттай ашигладаг бөгөөд хүссэн мэдээлэл хангалттай авч, үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байна гэж хариулсан байна.	
4.2.3	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;	-	Хариулсан дуудлагын тоо, дуудлага алдалтын хувь	Нийт 114,164 дуудлага ирж, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын байгууллага дуудлага алдалтын тоог 20 хувиас	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, дуудлага алдалтын тоог 18 хувиас хэтрүүлэхгүй ажиллана.	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээлэл өгөх “Callpro” дуудлагын тайланг долоо хоног бүр, нийт 20 удаа системээс татаж, дүн шинжилгээ хийн, үр дүнг тухай бүр дотоод мэдээллийн системээр мэдээлж ажиллав. Тайлант хугацаанд 268,803 дуудлага ирснээс 251,943 дуудлагад хариулж, алдсан дуудлага 16,659 ба дуудлага алдалтын дундаж 6 % байв.	85

				хэтрүүлэхгүй ажилласан.			
4.2.4	Нийгмийн даатгалын сангаас олгох зарим төрлийн тэтгэврийг цахимжуулах ажлыг зохион байгуулах;	-	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Нийгмийн даатгалын үйлчилгээний 85%-ийг цахимжуулсан.	Олон хүүхэдтэй эхийн нөхцлөөр тогтоох өндөр нас, энгийн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг цахимаар хүсэлт гаргах, тогтоох, олгох бэлтгэл ажил хангагдсан байна	“Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” А/138 дугаар тушаалаар батлав. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд зарим төрлийн тэтгэвэр түүний дотор олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоох өндөр нас, энгийн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр цахимжуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахаар тусгасан. Бэлтгэл ажлын хүрээнд тэтгэвэр, тэтгэмж тогтоох нийгмийн даатгалын үйлчилгээг төрийн архив, цэрэг, цагдаа, төмөр зам гэх мэт төрөлжсөн тусгай архивын байгууллагуудаас гарч байгаа зарим нэг төрлийн шийдвэр, архивын лавлагаа, тодорхойлолтыг цахимаар солилцох боломжийг бий болгох, санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ байгуулах замаар тэдний оролцоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Мөн Алба хаагчдын ажилласан жилийн талаарх тушаал шийдвэр, цалингийн тооцоо мэдээллийг цахимаар солилцох үүрэг бүхий ажлын хэсгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/111 дүгээр тушаалаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/142-А/208 дугаар тушаалаар байгуулан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай эхний уулзалтыг зохион байгуулав.	70
4.2.5	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэд,	-	Шинээр бэлтгэсэн контентын тоо, төрлийг 1-2 хувиар нэмэгдүүлсэн	Рийл 16, постер мэдээлэл 112, контент 4, цаг үеийн мэдээ, мэдээлэл 36,	Шинэ контент бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сошиал сүлжээгээр	Тайлант хугацаанд Рийл 27, Стори рийл 3, постер мэдээлэл 125, контент 6, мэдээ мэдээлэл 72, лайв 4 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээж, давхардсан тоогоор 8,176,960 хүнд хүрч 39,271 удаа түгээв.	100

	даатгуулагчдад ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент бэлтгэн хүргэх;		байна.	нэвтрүүлэг 3, подкаст 1, видео, танилцуулга, заавар 28, шторк 1 буюу 223 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээж, давхардсан тоогоор 8,945,678 хүнд хүрч 47,969 удаа түгээсэн.	дамжуулан сурталчилсан байна.		
4.2.6	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр төрийн болон олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;	-	-Хамтран ажилласан байгууллагын тоо, - Сурталчилгааны хувь, үр дүн	-	Төр болон хувийн хэвшил, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байна.	Хэвлэл мэдээллийн 18 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулав. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 30 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 210 (давхардсан тоогоор) удаагийн мэдээ, мэдээлэл, ярилцлага, тодруулга, хэлэлцүүлэгт оролцож нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан, түгээж ажилласан.	100
Зорилт 4.3: “Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.3.1	Эрүүл мэндийн магадлалтай холбоотой эрхзүйн баримт бичигт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, хүргүүлэх;	-	Саналыг боловсруулж, хүргүүлсэн байна.	2024 онд 2 санал боловсруулж, хүргүүлсэн.	Эрүүл мэндийн магадлалтай холбоотой 2 эрхзүйн баримт бичигт өөрчлөлт оруулах санал боловсруулж, ГБХНХЯ-нд хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн өөрчлөлтөд тусгуулах 6 саналыг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны өдрийн 01/763 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. /2025.04 сар/ Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх, сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээнд хамрагдсан	100

						байдал болон эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлд хяналт тавихад эрүүл мэндийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг солилцох зорилгоор мэдээллийн жагсаалт, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд цахимаар илгээх үечилсэн дүгнэлтийн загварыг тус тус боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/901 дүгээр албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжлан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/125, А/212 дугаар хамтарсан тушаалаар батлуулав. /2025.05 сар/	
4.3.2	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинээр нэвтрүүлж буй программын хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, хэвийн үйл ажиллагааг бүрдүүлэх зорилгоор санал, программын даалгаврыг Мэдээлэл технологийн төвд тухай бүрд хүргүүлэх;	-	-Хүргүүлсэн санал, -Программын даалгавар	-	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинээр нэвтрүүлэх, программын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүргүүлсэн саналын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлан шийдвэрлэх, эмнэлгийн хуудасны бичилт, олголтын болон эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн төлбөр, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн үндэслэл зэрэгт цахимаар хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нартай “Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах гэрээ” байгуулж хамтран ажиллах талаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Мэдээлэл солилцох тухай” 01/557 дугаар албан бичгээр албан хүсэлт хүргүүлсэн болно. /2025.04 сар/ Дээрх ажлын хүрээнд Мэдээллийн технологийн төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран иргэний эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл солилцох үйл ажиллагааны урьдчилсан туршилтыг хийж байна. /2025.06 сар/	90
4.3.3	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн Хамтарсан болон	-	Хяналт шалгалтын дүн, тайлан	Дахин магадлалыг Орхон, Говьсүмбэр,	Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу 8-аас доошгүй аймаг,	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн Дахин магадлалыг 4 дүүрэг, 1 аймагт зохион байгуулав. Үүнд:	100

	Дахин магадлал зохион байгуулах;			Төв аймаг, хамтарсан магадлалыг Дархан-Уул, Хөвсгөл, Булган, Дундговь аймаг, Хан-Уул дүүрэгт зохион байгуулсан.	дүүрэгт зохион байгуулсан байна.	Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг, Орхон аймагт зохион байгуулсан дахин магадлалд нийт 1,420 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг магадласнаас 1,353 /95.3%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадлаж, 32 /2.3%/ даатгуулагч, хүний заалт, хувь, хугацааг өөрчилж, онош эргэлзээтэй, заалт хувь, хугацаа зөрсөн, оношийн баталгаажилт хангалтгүй 51 /3.6%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 23 /1.6%/ иргэнийг онош баталгаажуулах шинжилгээнд илгээж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, нийгмийн даатгалын санд учруулсан 7016.7 мянган төгрөгийн хохирлыг санд буцаан төлүүлэхээр Улсын байцаагчийн акт тогтоож биелэлтийг хангуулж ажиллав. Хяналт шалгалтын хугацаанд Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн 200 орчим эмч, мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн магадлалын хууль эрхзүйн шинэчлэлт түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулав. 2025.02-05 сар/	
4.3.4	Мэдээллийн технологийн төвтэй хамтран Эрүүл мэндийн магадлалын болон цахим эмнэлгийн хуудасны программд өөрчлөлт оруулах, программын даалгавар боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах;	-	-Боловсруулж хүргүүлсэн 1 программын даалгавар	-	Холбогдох программд өөрчлөлт хийгдэж, боловсронгуй болсон байна.	Засгийн газрын 2023 оны 488 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-д заасан чиг үүргийн хүрээнд салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь даатгуулагч, хүнийг биеэр байлцуулахгүйгээр цахим болон баримт бичигт үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх, эмнэлгийн хуудасны үндэслэлд хяналт тавих үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахад иргэний эрүүл мэндийн мэдээллийг холбогдох байгууллагаас авах, мэдээлэл солилцох, магадлагч эмчийн зүгээс тавих хяналтыг цахим хэлбэрт шилжүүлэх шаардлага тулгарч байна. Иймд “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн	90

						дэд системийн программын даалгавар”, Тэтгэмжийн хяналтын дэд системийн “Магадлагч эмчийн хяналтын хэсэг”-т өөрчлөлт оруулах 13 санал боловсруулан Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны “Хамтран ажиллах тухай” 09/17 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төвд хүргүүлэн, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. /2025.02-06 сар/	
4.3.5	Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох сунгах, цуцлах үйл ажиллагааг бусад аймаг, дүүргийн ЭММЗ-өөр шийдвэрлэх боломжийг судлах, тогтолцооны санал боловсруулж хүргүүлэх;		Боловсруулсан 1 санал	-	Санал боловсруулж, ГБХНХЯ-нд хүргүүлсэн байна.	УИХ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрүүл мэндийн магадлалын процессын цахимжуулалтад тулгуурлан даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох үйл ажиллагааны чанарыг сайжруулах, үнэн зөв, шуурхай шийдвэрлэх, аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ачааллыг тэнцвэржүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах арга замыг тодорхойлох, төрийн байгууллага хоорондын мэдээллийн солилцоог сайжруулах зорилгоор “Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд цахим шинэчлэл нэвтрүүлэх хөтөлбөр” боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/152 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэхдээ санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон бусад аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар шийдвэрлэх боломжтой болох юм. /2025.05-06 сар/	100
Зорилт 4.5: “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.5.1	Салбарын хэмжээнд хууль		Нийгмийн даатгалын	-Нийгмийн даатгалын багц	Салбарын хэмжээнд хэрэгжиж	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль, тогтоомж, шийдвэрийн	100

	тогтоомжийн өөрчлөлт болон шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг мэдээллийн технологиор дэмжин ажиллах;		үйлчилгээг мэдээллийн дэвшилтэт технологид суурилан үзүүлэх үйлчилгээний хэвийн ажиллагааг хангасан байх.	хуулийн 100 гаруй зүйл заалтын дагуу мэдээллийн нэгдсэн системд холбогдох өөрчлөлт хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлсэн. -Нийгмийн даатгалын багц хуулийн дагуу 4 бүтээгдэхүүн шинээр хөгжүүлэн нэвтрүүлсэн. -Засгийн Газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 тоот тогтоолын дагуу нийт 520.0 мянга орчим тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх өөрчлөлтийг хийсэн. -“Нийгмийн даатгал” аппликейшнийг	буй хууль, тогтоомж, шийдвэр, өөрчлөлтийн хүрээнд системд зохих хөгжүүлэлтийг хийж нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологиор дэмжсэн байна.	хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээллийн системд холбогдох өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлэн ажиллав. Тухайлбал: Системд өөрчлөлт, хөгжүүлэлт хийж нэвтрүүлэх чиглэлээр: 1.Нийгмийн даатгалын цахим системийн ашиглалтын талаар даатгуулагч, ажил олгогчийн ашиглаж буй Portal.ndaatgal.mn веб хуудсаар дамжуулан судалгаа авч дараах хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлсэн. Үүнд: - Ажил олгогчийн портал системд нэвтрэх хэрэглэгчийн эрхийн тохиргоог шинэчилж дарга, нягтлан бодогч болон хүний нөөцийн ажилтнуудын ажлынх нь чиг үүргийн хүрээнд эрхийн хязгаарлалтуудыг хийсэн. - Ажил олгогч нийгмийн даатгалын тайлангаа тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр одоогийн байдлаар нийт 617 ажил олгогч тоон гарын үсгээр нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаа баталгаажуулан илгээсэн байна. - НД7А тайланд тусгагдсан акт алданги, торгуулийн мэдээллийг тоон гарын үсгээр зурах өгөгдөлд нэмж оруулсан. - НД7А тайланд ажил олгогчийн НДШ-ийн акт, алданги, торгуулийн дүнг тусад нь хүснэгтэд харуулах өөрчлөлтийг хийсэн. Мөн эдгээр дүнг нийт шимтгэл төлсөн дүнд тооцон харуулдаг болгосон. - Системийн шинэчлэлт, өөрчлөлт болон бусад шаардлагатай мэдээллийг ажил олгогчдод хүргэх зориулалт бүхий “Зар мэдээний булан”-г шинээр үүсгэсэн. 2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Гадаад харилцааны болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны “Адилтгах	
--	--	--	--	---	---	---	--

				шинэчлэн нэвтрүүлсэн. -Төрийн байгууллагуудт ай мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлэн шинээр 3 сервис нэвтрүүлсэн.	албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/48, А/130 дугаар хамтарсан тушаалын дагуу: - Цэргийн атташе, атташегийн туслахаар ажиллаж байсан даатгуулагчийн төрлийн 01001 кодоор тайлагнасан хугацааг цэргийн алба хаасны тэтгэвэр дээр хамтад нь тооцох - ТЕГ, АТГ зэрэг байгууллагаас даатгуулагчийн төрлийг 01001 кодоор тайлагнасан хугацааг цэргийн алба хаасны тэтгэвэр дээр хамтад нь тооцох болон бусад холбогдох өөрчлөлтүүдийг системд оруулж цэргийн атташе гэсэн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох боломжийг бүрдүүлсэн. 3.Үндсэн хуулийн цэцийн гишүүн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход, хүсэлт гаргах үед мөрдөж байсан албан тушаалын болон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлд заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулан тооцохтой холбогдуулан УИХ-аас 1995-2023 онуудад баталсан цалингийн мэдээллийг системд оруулсан. Ингэснээр тухайн жилд ажиллаж байсан ҮХЦ-ийн дарга, гишүүний цалингаар өндөр насны тэтгэвэр тогтоох боломж бүрдсэн. 4.Нийгмийн даатгалын нийт бүтээгдэхүүн үйлчилгээний тоон мэдээллийг дэлгэрэнгүй харах боломж бүхий “Dashboard”-ыг шинэчлэн боловсруулж нэвтрүүлсэн. Монгол улсын Засгийн Газрын болон бусад тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр: 1.Засгийн газрын 2024 оны “Итгэлцүүр батлах тухай” 231 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэрэглэх 2025 оны итгэлцүүрийг мэдээллийн системд оруулж 2025 онд шинээр	
--	--	--	--	--	--	--

						тэтгэвэр тогтооход ашиглах боломжийг бүрдүүлсэн. 2.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792,000 болсонтой холбогдуулан дараах өөрчлөлтийг хийсэн. Үүнд: - Бүх төрлийн сайн дураар даатгуулагчийн сард төлөх шимтгэл тооцох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792 000, дээд хэмжээг 5 544 000 төгрөг байхаар; - Албан журмаар даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээг 7 920 000 төгрөг байхаар өөрчлөх; - Тэтгэвэр тогтоох, тэтгэмж тооцох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 7 920 000 төгрөг байхаар. Шинээр бүтээгдэхүүн хөгжүүлэн нэвтрүүлэх чиглэлээр: 1.НДЕГ-ын даргын 2024 оны А/107 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам”-д заасан аргалчлалын дагуу даатгуулагчийн 2024 он ба түүнээс өмнөх хугацаанд сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээнээс илүү төлсөн шимтгэлийг системээр тооцоолон олгох бүтээгдэхүүнийг хөгжүүлэн нэвтрүүлэв. Үүний дүнд эхний 5 сарын байдлаар нийт 916 даатгуулагч илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт өгснөөс 431 даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийн тооцооллыг системээр хийж буцаан олгоод байна.	
4.5.2	Иргэд, даатгуулагчид руу чиглэсэн цахим үйлчилгээг өргөжүүлэх;		Иргэд, даатгуулагчид цахимаар үзүүлж буй үйлчилгээний төрөл	Нийгмийн даатгалын үйлчилгээний 85%-ийг цахимжуулсан.	Тэтгэврийн бүтээгдэхүүний хүсэлтийг цахимаар авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлсэн байна.	Иргэд, даатгуулагчид руу чиглэсэн цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд Portal.ndaatgal.mn веб систем, “Нийгмийн даатгал” аппликейшн болон төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн портал зэрэг гурван сувгаар даатгуулагчийн “Мөнгөжүүлсэн хуримтлал”-ын мэдээллийг он, оноор сонгож харах	IV улирал Хугацаа болоогүй

			нэмэгдсэн цахимжуулалт ын хувь			боломжийг бүрдүүлсэн.	
4.5.3	Нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд их өгөгдөл/хиймэл оюун ухаан үүсгэх ажилд оролцох;		Нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөлд нийлүүлсэн мэдээллийн тоон үзүүлэлт	-	Нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөлд нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг тогтмол нийлүүлсэн байна.	Нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд үүсгэх их өгөгдлийн (Big Data) системд шаардлагатай мэдээллийг хэрхэн нууцлан хамгаалах, мөн бусад байгууллагын өгөгдөлтэй хэрхэн уялдуулах талаарх аргачлалыг боловсруулах, батлах ажилд оролцлоо. Энэхүү аргачлалд суурилан мэдээлэл нийлүүлэхэд шаардлагатай өгөгдлийн сангийн бүтэц, өгөгдлийн талбарууд, формат, нууцлалын зэрэглэл зэргийг тодорхойлон холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан. Мөн улсын хэмжээнд үүсгэж буй их өгөгдлийн экосистемд өгөгдөл нийлүүлэх боломж, техникийн хэрэгжилтийг турших зорилгоор “И-Монгол” УТҮГ-тай хамтран туршилтын өгөгдөл дамжуулах, API холболт, өгөгдлийн формат, найдвартай байдал, хамгаалалтын түвшнийг шалгах тестүүдийг хийж гүйцэтгэж байна. Энэ хүрээнд харилцан тохирсон өгөгдлийн бүтэц, урсгалыг туршиж, шаардлагатай сайжруулалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн, Засгийн газрын төвлөрсөн “Дашбоард систем”-д зориулсан салбарын холбогдох мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж, тогтмол хүргүүлэн ажиллав.	III-IV улирал Хугацаа болооогүй
4.5.4	Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төрийн нэгдсэн мэдээллийн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой үзүүлэх;	-	1.Нэгдсэн мэдээллийн санг баяжуулсан байх 2.Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийсэн байх	1.Нэгдсэн мэдээллийн санг бодит цагийн горимоор цуглуулан ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн. 2.150 удаагийн мэдээллийн боловсруулалт хийсэн.	1.Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, нөөцлөх, төрийн нэгдсэн мэдээллийн санд байршуулах, нэгдсэн мэдээллийн сангаас үйлчилгээ үзүүлэх ажил тогтвортой хийгдсэн байна. 2.Нэгдсэн	1. Нэгдсэн мэдээллийн санг бодит цагийн горимоор цуглуулан ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллав. Төв орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагад өдөр бүр үүсгэж буй иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг цаг тухай бүр онлайнаар цуглуулан авч боловсруулан нэгдсэн мэдээллийн санг шинэчлэн баяжуулав. Ингэснээр төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагад үзүүлэх нийгмийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж, хэрэглэгч бодит цагийн	85

			3.Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан цахимаар мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлэн хэвийн ажиллагааг хангасан байх.	3.Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ: -135.2 мянган даатгуулагч, ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт цахимаар авсан. -149.0 мянган даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, төлбөрөө төлөх үйлчилгээнд цахимаар хамрагдах боломжийг бүрдүүлсэн. -1150 эрүүл мэндийн байгууллагаас 183.3 мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 61.7 мянган даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт 245	мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийх ажлыг цаг тухай бүр гүйцэтгэсэн байна. 3.Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан иргэд, даатгуулагч, төрийн болон бусад байгууллагуудад цахимаар мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна.	горимоор цахим үйлчилгээг тухай бүр хэвийн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллав. 2. Нэгдсэн мэдээллийн сангаас 140 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа гаргав. УИХГ, яам, агентлаг, төрийн болон бусад байгууллагын хүсэлтээр нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сангаас нийтдээ 140 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгааг гарган хэрэглэгчийг мэдээллээр ханган ажиллав. Тухайлбал: УИХ-ын нэр бүхий 3 гишүүний хүсэлтээр: - 2015-аас 2025 оны 1 улирлын байдлаарх даатгуулагчийн цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, төлсөн шимтгэлийн хэмжээ, даатгуулагчийн тоон мэдээллийг 4 удаа; Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүсэлтээр: - Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө, дундаж тэтгэврийн хэмжээг өгөгдсөн интервалын дагуу тэтгэврийн төрөл болон хүйсээр; - Цэргийн тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авагчдын хөдөлмөрийн чадвараа алдсан жил, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хөдөлмөрийн чадваргүй иргэний тоон мэдээллийг; - Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагсдын мэдээллийг; - Сүүлийн 5 жилд тэтгэвэр авсан тэтгэвэр авагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, нэрийн дансны мэдээлэл, нийт авсан тэтгэврийн дүн, тэжээгчээ алдсан үүссэн эсэх талаар мэдээллийг; - 2024 онд малчин, туслах малчин төрлөөр сайн дурын даатгалд даатгуулсан нийт даатгуулагчийн нас, хүйс, шимтгэл төлсөн сар, “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” болон “Малчин, хувиараа хөдөлмөр	
--	--	--	---	--	--	--	--

				мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн. -Иргэд даатгуулагч, ажил олгогч E-Mongolia нэгдсэн порталаар нийт 14.8 сая удаагийн хандалт хийж нийгмийн даатгалын 12 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар авсан.		эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулиар нөхөн тооцсон эсэх мэдээллийг; - 10-аас дээш жил шимтгэл төлсөн, тэтгэврийн эрх үүсгээгүй, “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулиар нөхөн даатгалд хамрагдсан нийт даатгуулагчийн нас, хүйс, нөхөн төлсөн сарын мэдээллийг; Үндэсний статистикийн хороонд: - ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2024 оны 4-р улирал, 2024 оны жилийн эцсийн байдлаарх ААНБ-ын даатгуулагчдын тоо, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, сарын дундаж цалинг өгөгдсөн интервал, хүйс, аймаг болон бүс, эдийн засгийн ангилал, ажил мэргэжлийн код, өмчийн хэлбэр, хариуцлагын хэлбэрээр. /Нийт 34 хүснэгтэн мэдээлэл/ - ҮСХ-ны даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаарх нийгмийн даатгалын салбарын нийт 28 хүснэгтэн мэдээллийг; Татварын ерөнхий газарт: - 2024 оны байдлаарх нийт даатгуулагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, төрлийн код, ногдуулсан шимтгэлийн хэмжээ зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг; Боловсрол, шинжлэх ухааны яаманд: - Тус яамнаас жагсаалтаар ирүүлсэн, Боловсролын зээлийн сангаас зээл авсан иргэдээс төрийн байгууллагад ажилласан даатгуулагчдын тоон мэдээллийг; Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт: - Халамжийн тэтгэвэр авдаг 65.0 мянган иргэнийг тэтгэвэр авдаг эсэх мэдээллийг; Шинэ хоршоо салбар дундын уялдааг хангах үндэсний хороонд:
--	--	--	--	--	--	---

					- УБЕГ-т хоршоогоор шинээр бүртгүүлсэн 9.3 мянган хоршооноос нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн хоршооны даатгуулагчдын тоон мэдээллийг; Авлигатай тэмцэх газарт: - Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг 9 удаа; ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн шалгах алба, Экологийн цагдаагийн албанд: - Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийтдээ 52 удаа гэх мэт. <i>3. Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар хүргэв.</i> Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан иргэд, даатгуулагч, төрийн болон бусад байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн хэвийн ажиллагааг ханган ажиллав. Үр дүнгээс дурдвал: - 44.0 мянган даатгуулагч, 51.2 мянган ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт цахимаар авсан байна. - 111.6 мянган даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, төлбөрөө төлөх үйлчилгээнд цахимаар хамрагдсан байна. - 910 эрүүл мэндийн байгууллагаас 78.8 мянган албан журмаар даатгуулагчийн, 6.9 мянган сайн дураар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 26.6 мянган даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт 112.3 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна. - 57.6 мянга гаруй ажил олгогчоос 1, 2, 3, 4, 5 дугаар саруудад цахимаар илгээсэн, давхардсан тоогоор 4.2 сая албан журмаар даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авсан байна.	
--	--	--	--	--	---	--

					- Нийт 12.9 мянган ажил олгогчоос цахимаар илгээсэн 78.8 мянган албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна. *** E-Mongolia нэгдсэн портал: Төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн порталаар иргэд даатгуулагч, ажил олгогч нийгмийн даатгалын 12 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар авч байна. 4. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар үзүүлэх зориулалт бүхий, иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг агуулсан, 60 гаруй төрлийн сервисийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. Түүнчлэн ХУР системээр дамжуулан үзүүлэх цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд: - Даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогын хэмжээг E-Mongolia нэгдсэн порталаар харуулах сервисийг шинээр боловсруулан ХУР системд байршуулсан. - Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолын дагуу тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах хүсэлтийг ХУР системээр дамжуулан E-Mongolia нэгдсэн порталаар цахимаар авах сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн. Эдгээр боломжийг бүрдүүлснээр оны эхний 5 сарын байдлаар ХУР системийн нийт хандалтын тоо 892.3 мянгад хүрч иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагуудад цахимаар үйлчилгээ авсан байна.	
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ						93.7

